



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 467

Улаанбаатар хот

“Үенч арвижин дэлгэрэх” ХЗХ-ны  
хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 245 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 7.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Үенч арвижин дэлгэрэх” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл сунгасугай.

2.Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтад холбогдох тэмдэглэгээг 21 хоногийн дотор хийлгэхийг “Үенч арвижин дэлгэрэх” ХЗХ (Р.Баярцэцэг)-нд үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН